



НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ  
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2019 06 18

043

Огноо сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Иргэн Б.Гансүхийн гомдлын тухай

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг Д.Сайханчулуун даргалж, гишүүд Д.Баяраа, Х.Төмөрбаатар, Х.Нямбаяр, Б.Төгслхам, нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэй, иргэн Б.Гансүхээс Сүхбаатар дүүргийн татварын улсын байцаагчийн 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 250011013 дугаар актад гаргасан гомдлыг, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ч.Байгалмаа, Б.Тунгалагтуул нарыг оролцуулан магадлагч-татварын улсын байцаагч Ж.Эрдэнэбүрэн магадлагаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

**ТОДОРХОЙЛОХ НЬ:**

1. Иргэн Б.Гансүх нь Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдолдоо: "Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ч.Байгалмаа, Б.Тунгалагтуул нарын 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 250011013 татварын улсын байцаагчийн акт нь иргэн Гансүх миний хууль ёсны эрх ашгийг ноцтойгоор зөрчсөн тул дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

Татварын улсын байцаагчийн 250011013 тоот актаар 1,485,000.0 төгрөгийн нөхөн татвар, 445,500.0 төгрөгийн торгууль, 162,162.0 төгрөгийн алданги бүгд 2,092,662.0 төгрөгийн төлбөр ногдуулсан.

Татварын байцаагч нар Татварын хуулиуд болон татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журмын 6.4.2, 6.4.3, 6.4.4, 6.4.11 дэх заалтуудыг зөрчсөний улмаас Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заасан үнэлгээг буруу гарган хэрэглэсэн. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно" гэсэн. Гэтэл татварын улсын байцаагч нар хаанаас яаж Чингэлтэй дүүргийн 15 хороонд байрлах 3 давхар нийтийн байрны зориулалттай 247,500,000.0 төгрөгөөр үнэлсэн нь хууль зөрчсөн байна. Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Дараахь үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас чөлөөлнө: 7.1.2. орон сууц" гэж орон сууцийг чөлөөлөхөөр заажээ.

Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:3.1.1."орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг" гэж заажээ.

Иймд илт хууль зөрчсөн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Тунгалагтуул, Ч.Байгалмаа нарын 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн

250011013 татварын улсын байцаагчийн актыг хүчингүй болгож иргэн Б.Гансүх миний зөрчигдсөн эрхийг сэргээж өгнө үү" гэж тэмдэглэсэн.

2. Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ч.Байгалмаа, Б.Тунгалагтуул нар тайлбартаа: "Үл хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх, вакуум цонх үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг, ХИ82112976 тоот регистрийн дугаартай, Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороо, 11 гудамж, 306 тоотод оршин суух Батмөнх овогтой Гансүхийн 2012 оны 05 сарын 21-ний өдрөөс 2015 оны 12 сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд «Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж», «Татварын хяналт шалгалт хийх томилолт», «Тэнгисийн хөх сүвд» ХХК-ийн 2016 оны 08 сарын 30-ны өдөр тус хэлтэст ирүүлсэн гомдлын дагуу санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Ч.Байгалмаа, Б.Тунгалагтуул нар иж бүрэн шалгалт хийсэн.

Тус иргэн нь 2012-2015 онд вакуум цонхны үйлдвэрлэл эрхэлдэг "Чанар үзэмж констракшн" ХХК-ийг эхнэр Б.Болорын хамтаар ажиллуулж, мөн Чингэлтэй дүүргийн 15 хороонд байрлах 3 давхар нийтийн байрны зориулалттай баригдсан барилгыг түрээслүүлэх үйл ажиллагаа явуулж байсан. Хяналт шалгалтын явцад ямар нэгэн баримт материал ирүүлээгүй бөгөөд вакуум цонхны үйлдвэрлэлийн орлого болон үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлогоо огт тайлагнаж байгаагүй, Хувь хүний орлогын албан татварын тасгийн байцаагчдыг татвар хураахаар ажлын байранд очиход манайх компаниараа үйл ажиллагаа явуулдаг гэсэн тайлбар өгч хувь хүний орлогын албан татвар төлдөггүй атлаа компанийн татварын тайлангаар Х тайлан ирүүлсэн байсан.

Хяналт шалгалтын ажлыг Хяналт шалгалтын үйл ажиллагааны журмын дагуу үе шат тус бүрээр бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд иргэн Б.Гансүх нь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн баримт материал ирүүлээгүй тул түүний нэр дээр бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 15 хороонд байрлах 3 давхар барилгад очиж ажлын зураг авалт, татвар төлөгчтэй ярилцлага хийсэн. Уг 3 давхар барилгын 1 давхрыг авто засварын газарт түрээслүүлдэг байсан. Иймээс ажлын байрны зураг авалт, татвар төлөгчтэй хийсэн ярилцлага зэрэгт тулгуурлан нийт 722 м.кв талбайгаас оршин сууж байсан 60 м.кв-ийг хасч үлдсэн талбайд үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулсныг үндэслэлтэй гэж үзэж байна." гэж тэмдэглэсэн.

3. Магадлагч-татварын улсын байцаагч Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, тайлбар, татварын болон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, журналын бүртгэл зэрэг холбогдох материалд тулгуурлан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжид үндэслэн магадлагаа хийж, татварын улсын байцаагчийн 250011013 тоот актаар 247,500,000.0 төгрөгийн зөрчил илрүүлж 1,485,000.0 төгрөгийн нөхөн татвар, 445,500.0 төгрөгийн торгууль, 162,162.0 төгрөгийн алданги бүгд 2,092,662.0 төгрөгийн төлбөр тогтоосныг бүхэлд нь хүчингүй болгох гэсэн саналыг оруулсан.

#### ҮНДЭСЛЭХ НЬ:

Иргэн Б.Гансүхийн 2012-2015 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ч.Байгалмаа, Б.Тунгалагтуул нар хяналт шалгалт хийж, 247,500,000.0 төгрөгийн зөрчил илрүүлж 1,485,000.0 төгрөгийн нөхөн татвар, 445,500.0 төгрөгийн торгууль, 162,162.0 төгрөгийн алданги нийт 2,092,662.0 төгрөгийн төлбөр ногдуулсныг эс зөвшөөрч гомдол гаргажээ.

Иргэн Гансүхийн 2012-2015 оны албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Тунгалагтуул, Ч.Байгалмаа нар Татварын ерөнхий газрын хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу

шалгалт хийсэн. Татварын улсын байцаагчийн 250011013 дугаар актаар 1 төрлийн 247,500,000.0 төгрөгийн зөрчил илрүүлснийг эс зөвшөөрч гомдол гаргасан. Үүнд:

Татвар төлөгч 2015 онд 247,500,000.0 төгрөгийн үнэлгээтэй хөрөнгөнд үл хөдлөх хөрөнгийн татвар ногдуулаагүй зөрчил нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг зөрчсөнийг тэмдэглээд Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 заалтын үндэслэн хариуцлага тооцсонд хуулинд татвараас чөлөөлөгдөхөөр заасан байхад орон сууцны зориулалттай барилгад үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулсан нь хууль зүйн үндэслэлгүй гэж маргасан.

Иргэн Б.Гансүх нь Чингэлтэй дүүргийн 15 хорооны 11 дүгээр гудамжны 306 тоотод 3 давхар 30 өрөө, дороо граштай нийтийн байрны зориулалттай барилгыг Төрийн банк, Хас банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн эх үүсвэрээр барьж гүйцэтгэсэн байна.

Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д «Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1. "орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг» тодорхойлсон бөгөөд Чингэлтэй дүүргийн 15 хорооны 11 дүгээр гудамжны 306 тоотод 30 өрөө бүхий 3 давхар барилгад Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн газраас амины орон сууц гэсэн гэрчилгээг олгосон нь дээрх хуулийн шаардлагад нийцэж байна.

Мөн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д «Дараахь үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас чөлөөлнө: 7.1.2. орон сууц», Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийг хэрэгжүүлэх аргачлалын 6 дугаар зүйлийн 6.1.2-д «Орон сууцны зориулалттай байшин барилгын нэг хэсэгт нь үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, нөгөө хэсэгт нь хүн амьдран суудаг бол тухайн байшин барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа хэсгийн үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас чөлөөлөхгүй» гэж заасан байх тул грашийн хэсэгт үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах нь зүйтэй байна гэж зөвлөлийн бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.

Иймд 67,500,000.0 төгрөгийн үнэлгээтэй грашийн хэсэгт үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулаагүй зөрчил нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д «Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараахь этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна: 4.1.1. өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газар», мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д «Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно», 6 дугаар зүйлийн 6.1-д «Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-1.0 хувиар тооцож ногдуулна», 8 дугаар зүйлийн 8.2-д «Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварыг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр тооцож төлнө» гэсэн заалтыг зөрчсөн байх тул Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 дах заалтыг үндэслэн 405,000.0 төгрөгийн нөхөн татвар, 121,500.0 төгрөгийн торгууль, 44,226.0 төгрөгийн алданги нийт 570,726.0 төгрөгийн төлбөрийг ногдуулснаас «Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай» хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д «Хууль тогтоомж зөрчиж захиргааны зөрчил гаргасан

болон шийтгэл хүлээсэн этгээдийг өршөөн хэлтрүүлнэ», мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д «Энэ хуулийн 3.1-д заасан "гэмт хэрэг үйлдсэн хүн" гэдэгт 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө гэмт хэрэг үйлдсэн болон ял шийтгүүлсэн, захиргааны зөрчил гаргасан болон шийтгэл хүлээсэн хүн хамаарна» гэж заасныг үндэслэн 60,750.0 төгрөгийн торгууль, 22,113.0 төгрөгийн алданги нийт 82,863.0 төгрөгийн төлбөрийг өршөөлийн хуульд хамруулах нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 7 дахь заалтыг удирдлага болгон

#### ТОГТООХ НЬ:

1. Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.2, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийг хэрэгжүүлэх аргачлалын 6 дугаар зүйлийн 6.1.2, Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг үндэслэн татварын улсын байцаагчийн 250011013 дугаар актаар 247,500,000.0 төгрөгийн зөрчилд 1,485,000.0 төгрөгийн нөхөн татвар, 445,500.0 төгрөгийн торгууль, 162,162.0 төгрөгийн алданги нийт 2,092,662.0 төгрөгийн төлбөр төлүүлэхээр тогтоосноос 180,000,000.0 төгрөгийн зөрчилд 1,080,000.0 төгрөгийн нөхөн татвар, 324,000.0 төгрөгийн торгууль, 117,936.0 төгрөгийн алданги бүгд 1,521,936.0 төгрөгийн төлбөрийг хүчингүй болгож, 60,750.0 төгрөгийн торгууль, 22,113.0 төгрөгийн алданги нийт 82,863.0 төгрөгийн төлбөрийг өршөөлийн хуульд хамруулах, 67,500,000.0 төгрөгийн зөрчилд 405,000.0 төгрөгийн нөхөн татвар, 60,750.0 төгрөгийн торгууль, 22,113.0 төгрөгийн алданги бүгд 487,863.0 төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр актыг өөрчилсүгэй.

2. Шийдвэрийг эс зөвшөөрвөл актад гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ХУРАЛ ДАРГАЛСАН:

ГИШҮҮД:

 Д.САЙХАНЧУЛУУН

 Д.БАЯРАА

 Х.ТӨМӨРБААТАР

 Х.НЯМБАЯР

 Б.ТӨГСЛХАМ

 Ж.ЭРДЭНЭБҮРЭН